

**Дундговь аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайланда хийгдсэн Төрийн аудитаарх акт, албан шаардлагын хэрэгжилт**

<b>№</b>	<b>Зөрчил</b>	<b>Шаардах нь:</b>	<b>Хэрэгжилтийн хугацаа</b>	<b>Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b>	<b>Хэрэгжилтийн хувь</b>
1	Хяналтын тоолого хийх явцад бараа материалын тайлангийн үлдэгдэлд тайлагнасан 3,600,000 төгрөгийн У.Хүрэлсүх ном дутагдсан	Дутагдуулсан хөрөнгийн үнэ болох 3,600,000 төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх	21.05.25	Дундговь аймгийн Цагдаагийн газарт хэрэг үүсгэн шалгуулахар албан тоот егсөн болно.	50%
2	Албан хаагчдын биеэр эдлээгүй амралтын хоногт ногдох урамшууллыг дундаж цалин хөлснөөс тооцож 3,060,997 төгрөгийн урамшууллыг илүү олгосон	Албан хаагчид илүү тооцож олгосон 3,060,997 төгрөгийг Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд төвлөрүүлэх	21.05.25	2020 онд ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ц.Эрдэнэсүрэн, нягтлан бодогч Д.Нандинцэцэг нарт уг төлбөрийг барагдуулах талаар албан тоотоор мэдэгдэл хүргүүлсэн болно.	50%
3	Засаг дарга болон ЗДТГазраас гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйлс, хүндэтгэлийн зоог барихдаа батлагдсан хэмжээг хэтрүүлэн 25,834,964 төгрөгийг зарцуулалтын тайлангүй, төлөөлөгчдийн тоо тодорхойгүй, бүрдэл дутуу анхан шатны баримтаар гүйлгээ хийж зарцуулсан.	Төсвийн хөрөнгийн үр ашигтай, батлагдсан хэмжээг баримтлан хэмнэлттэй байхаар зарцуулж, хяналт тавих	21.05.20	Засаг дарга болон ЗДТГазраас гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд бэлэг дурсгалын зүйлс, хүндэтгэлийн зоог барихдаа Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.05.20 №85 дугаар тогтоолыг үндэслэн зардлыг хэтрүүлэхгүй зочин төлөөлөгчдийн тоо тодорхой тушаалыг үндэслэн гүйлгээг хийж байгаа болно.	100%
4	Орон тоо, цалингийн сан батлагдаагүй Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын орон тоо дээр цалин, ажил хавсарсны нэмэгдэл 10,759,118 төгрөгийг олгосон	Батлагдсан орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоог батлах	21.05.25	Аймгийн ЗДТГ-ын даргын 2021.05.05 А/178 "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар ЗДТГ-ын бүтэц орон тоог шинэчлэн батлах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	80%

	Төсвийн хөрөнгөөр 59,732,200 төгрөгийг үндсэн хөрөнгө, бэлэг дурсгалын зүйлс худалдан авах гэрээ байгуулаагүй, төсвийн хяналтгүй зарцуулсан	Төсвийн хөрөнгийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж, хяналт тавьж, худалдан авалт хийхдээ гэрээг байгуулж хөвших, Цаашид гэрээний хэрэгжилтийг хангаж, ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгсөн үед ажлын хөлс төлөх, Гүйцэтгэгч компаниар ажлыг гэрээний хугацаанд хийлгэн хүлээн авч, бүртгэл тайландаа тусгах	Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулж, гэрээг дүгнэж, бараа материал, ажлыг хүлээн авах акт Үйлдсэний дараа төлбөрийг шилжүүлэж, бүртгэл тайландаа тусгана ажиллаж байна. 2021 оны 01 сарын 01 өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдөр хүртэл нийт 20 байгуулагатай гэрээ байгуулж, бараа ажил үйлчилгээг хүлээн авсан комиссын акт үйлдэн бараа материал, үндсэн хөрөнгийн тайландаа тусган ажилласан болно.	
5	Ажил гүйцэтгэх гэрээг зөрчин гэрээг дүгнээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад 9,900,000 төгрөгийг шилжүүлсэн		Ажил гүйцэтгэгч компанийт холбогдох гэрээний дагуу ажлыг бүрэн гүйцэд хүлээлгэж өгхийг мэдэгдсэн болно.	100%
6	Санхүүгийн тайландаа тусгаагүй 38,856,688 төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, зардлаар тайлагнасан. Нийтлэг үйлчилгээ орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өр төлбөр	Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах	Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, зааврыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж зөвлөмжийг мөрдөж ажиллах болно.	50%
7	Бэлтгэн нийлүүлэгч компаниас 2,600,000 төгрөгийн хөрөнгийг биетээр хүлээн аваагүй боловч төлбөрийг шилжүүлж, тооллогын бүртгэлд тусган санхүүгийн тайландаа тусгасан.	Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд нүд үзэн тоолж, үнэн зөв, чанартай явуулах	Бэлтгэн нийлүүлэгч компаниас хөрөнгийг хүлээн авч, хөрөнгө хүлээн авсан акт үйлдэж хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан болно. Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд чанартай, үнэн зөв явуулах болно.	
8			M.Янжиндолгор	100%

Хэрэгжилт гаргасан:

